



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/120

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.8, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн, 5.2 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 8.1.12.13, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2023 оны А/419 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл шинээр олгох хуулийн этгээдийн нэрсийг нэгдүгээр, Спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох хуулийн этгээдийн нэрийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар), Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн)-т тус тус даалгасугай.

3. Захирамжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хууль, дүрэм журам, стандартыг зөрчсөн нь тогтоогдвол тусгай зөвшөөрлийг цуцалж хуулийн этгээдэд мэдэгдэхийг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

АЖИЛ 2024 он ажил захирамж

1123200204